



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 104

Эрдэнэт

Орон нутгийн хамгаалалтад
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.к дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Баян-Өндөр сумын Овоотын газар бүхий 983,16 га, Баян-Өндөр, Жаргалант сумын Хуурай ам, Хөөврийн хөндийн газар бүхий 2272.98 га, Жаргалант сумын Хөндлөн намгийн газар бүхий 6933.48 га газруудыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2. Орон нутгийн хамгаалалтад авсан 983.16 га газрын хилийн заагийг нэгдүгээр хавсралтын ёсоор, 2272.98 га газрын хилийн заагийг хоёрдугаар хавсралтын ёсоор, 6933.48 га газрын хилийн заагийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

00100298